

Байгууллагын мэдээллийн нууцыг “Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 22 дугаар зүйлийн 3 дугаар заалтын дагуу нууцлан хадгална.

Үндэсний статистикийн газрын даргын тушаалаар батлав.
2002 оны 02 сарын 27-ны өдөр Тушаал № 37

Улсын тайлан маягт ТББ - 1

**ТӨРИЙН БУС БОЛОН ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГЫН
ОРЛОГО, ЗАРЛАГЫН 200. . . ОНЫ . . . -Р УЛИРЛЫН ТАЙЛАН**

Хэсэг 1. Хаягийн хэсэг

Регистрийн дугаар							
Байгууллагын нэр							
Байршил	Нэр		Код				
Аймаг, нийслэл							
Сум, дүүрэг							
Баг, хороо							
Хороолол							
Гудамж, байшин							
Хашаа хаалга							
Үйл ажиллагааны салбарын чиглэл							

1. Төрийн бус болон олон нийтийн байгууллагууд мэдээг жил бүрийн 3-р сарын 5-ны дотор аймаг нийслэлийн статистикийн хэлтэст
2. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс жил бүрийн 3-р сарын 21-нд ҮСГ-т электрон шуудангаар ирүүлнэ.
1. Тодруулсан хэсгийн үзүүлэлтүүдийг төрийн бус ба олон нийтийн байгууллагууд улирал бүрийн дараа сарын 15-ны дотор аймаг, нийслэл (дүүрэг)-ийн статистикийн албанд ирүүлнэ.
2. Аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, тасаг нь ҮСГ-т улирлын дараа сарын 21-нд e-mail-ээр ирүүлнэ.

Хэсэг 2. Эдийн засгийн үзүүлэлт

Үзүүлэлт	Мөрийн дугаар	Гүйцэтгэл (мян. төгрөг)
А	Б	В
1. Үйл ажиллагааны нийт орлого мөр 1 = мөр (2 : 5)+ (9:15)	1	
Гишүүний татвар	2	
Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив	3	
Өвлүүлсэн эд хөрөнгө	4	
Зээлийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор олсон орлого мөр 5 = мөр (6 : 8)	5	
Үүнээс: улсын төсвөөс	6	
олон улсын байгууллагаас	7	
бусад	8	
Үндсэн хөрөнгө худалдсаны орлого	9	
Хүүгийн орлого	10	
Ногдол ашгийн орлого	11	
Даатгалын байгууллагаас авсан нөхөн төлбөр	12	
Төлбөрт үйлчилгээний орлого	13	
Аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого	14	
Бусад орлого	15	
2. Нийт зарлага мөр 16 = мөр (17 : 38)	16	
Цалин хөлс	17	
Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	18	
Нийгмийн даатгалын шимтгэл	19	
Үндсэн хөрөнгийн элэгдэл	20	
Түрээсийн төлбөр	21	
Цахилгаан, эрчим хүч	22	
Дулаан	23	
Цэвэр, бохир ус	24	
Хөдөлмөр хамгаалал	25	
Даатгалын хураамж	26	
Албан томилолт	27	
Ажиллагсад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж	28	
Хүүгийн зардал	29	
Ажилчдын сургалт, давтан сургалт	30	
Засвар үйлчилгээ	31	
ОУ-ын байгууллагын гишүүний татвар	32	
Тээврийн зардал (шатахуун)	33	
Шуудан, холбоо	34	
Интернетийн зардал	35	
Бичиг хэрэг	36	
Зар сурталчилгааны зардал	37	
Бусад зардал	38	
3. Нийт ажиллагсдын тоо мөр 39 = мөр (40 + 41)	39	
Үүнээс: бүтэн цагаар ажиллагсдын тоо	40	
бүтэн бус цагаар ажиллагсдын тоо	41	
Эмэгтэй ажиллагсдын тоо (мөр 42 <= мөр39)	42	
4. Компьютерийн тоо, тоогоор	43	

Хэсэг 3. Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал (мян. төг)


	Мөр	Бүгд		Өөрийн хөрөнгөөр тухайн жилд оруулсан Хөрөнгө оруулалт
		оны эхэнд	оны эцэст	
А	Б	1	2	3
1. Үндсэн хөрөнгө мөр 44 = мөр (45 + 58)	44			
Биет хөрөнгө мөр 45 = мөр (46+47+51+52+55)	45			
- орон сууцны барилга	46			
- бусад барилга, байгууламжууд мөр 47 = мөр (48 + 49)	47			
орон сууцны бус барилга	48			
бусад байгууламжууд	49			
үүнээс: авто зам	50			
- их засвар, өргөтгөл, шинэчлэлт, сэргээн босголтын ажил	51			
- машин, тоног төхөөрөмж мөр 52 = мөр (53 + 54)	52			
тээврийн хэрэгсэл	53			
бусад машин, тоног төхөөрөмж	54			
- өсөж үрждэг хөрөнгө мөр 55 = мөр (56 + 57)	55			
ажлын болон ашиг шимийн мал, амьтан	56			
олон наст ургамал	57			
Биет бус хөрөнгө мөр 58 = мөр (59 : 62)	58			
- геологи, хайгуул, зураг төслийн ажил	59			
- компьютерийн программ хангамж	60			
- утга зохиол, урлагийн эх бүтээл	61			
- бусад биет бус үндсэн хөрөнгө	62			
2. Материаллаг эргэлтийн хөрөнгө мөр 63 = мөр (64+65+ 68+69)	63			
Түүхий эд, материал	64			
Дуусаагүй үйлдвэрлэл мөр 65 = мөр (66 : 67)	65			
- өсөж үрждэг бүтээгдэхүүнээс тооцсон дуусаагүй үйлдвэрлэл	66			
- бусад дуусаагүй үйлдвэрлэл	67			
Бэлэн бүтээгдэхүүн	68			
Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүн	69			
3. Үнэт зүйлс мөр 70 = мөр (71 : 73)	70			
Үнэт металл, чулуу	71			
Эртний эдлэл, бүтээл	72			
Бусад үнэт зүйлс	73			
ХӨРӨНГИЙН НИЙТ ХУРИМТЛАЛ мөр 74 = мөр (44+63+70)	74			

Тэмдэглэгээний тайлбар: () харгалзах үзүүлэлтүүдийн хоорондох тоонуудын нийлбэр
 Жишээ нь: мөр (6 : 8) = мөр (6+7+8)
 (<=) харгалзах үзүүлэлтээс бага буюу тэнцүү

Хэсэг 4. Харилцах хаяг

Харилцах хүний нэр		
Албан тушаал		
Байршил	Нэр	Код
Аймаг, нийслэл		
Сум, дүүрэг		
Баг, хороо		
Хороолол		
Гудамж, байшин		
Хашаа, хаалга		

Шуудангийн хайрцаг		Факсын дугаар	
Утасны дугаар	1.	2.	3.
Гар утас	1.	2.	3.
E-mail-ийн хаяг			



Захирал (эзэн)овог, нэр /...../
 Ерөнхий (ахлах) нягтлан бодогч

200... оны сарын-ны өдөр

Судалгааны зорилго.

Судалгааны зорилго нь ашгийн бус байгууллагын нийт үйлдвэрлэлийг тооцоход шаардлагатай орлого, зарлагын талаархи мэдээллийг цуглуулах зорилготой.

ТББ-1 Маягт нөхөх заавар

Хэсэг 1. Хаягийн хэсэг

ТББОНБ-ын хаягийн хэсэг нь ҮСГ-ын ТББОНБ-ын санд өөрчлөлт, баяжилт хийхэд чухал ач холбогдолтой мэдээлэл юм. Хаягийн хэсэг нь тухайн байгууллагын оршин байгаа хаяг, харилцах хаяг гэдэг нь мэдээллийг тухайн газраас авах хаяг болно.

Хэсэг 2. Эдийн засгийн үзүүлэлт

1-р мөрөнд үйл ажиллагаа явуулж олсон нийт орлогын хэмжээг нөхнө.

15 мөрөнд бусад орлогын хэмжээг нөхнө.

17-38-р мөрний үзүүлэлтүүдийг СТ-2 болон зохих зардлын дансуудаас авч нөхөн дүнг **16-р мөрөнд** дүгнэнэ.

17-р мөрөнд үндсэн ба нэмэгдэл цалин хөлс, шагнал, цалинд олгосон бүтээгдэхүүн, хоол түлээ нүүрс, байрны хөнгөлөлт зэрэг орно.

26-р мөрөнд нийгмийн даатгалын шимтгэлээс бусад даатгалыг нөхнө. Ж: хөрөнгийн даатгал г.м

31-р мөрөнд үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдсон урсгал засвар, үйлчилгээний зардал орно. Үйлдвэрлэлийн хэрэгслийг өргөтгөх, шинэчлэхтэй холбогдсон зардал нь капиталыг бий болгох зардал буюу хөрөнгө оруулалтанд тооцогдох тул энд орохгүй.

38-р мөрөнд бусад зардалын нийт дүнг нөхнө.

39-р мөрөнд Нийт ажиллагсдын тоог жилийн дунджаар тооцож нөхнө.

Олон улсын нэгдсэн ангиллын дагуу ажиллагсдыг бүтэн, бүтэн бус цагаар ажилладаг ажиллагсад гэж ангилдаг. Бүтэн цагаар ажиллагсад гэдэгт хөдөлмөрийн хуулиар тогтоосон цагийн дагуу ажилладаг ажиллагсад, бүтэн бус цагаар ажиллагсдад хэд хэдэн байгууллагад гэрээгээр ажилладаг, амралт, чөлөөт цагаараа ажилладаг, хуулийн дагуу богиносгосон цагаар ажиллагсдадыг оруулна.

42-р мөрөнд эмэгтэй ажиллагсдын тоог нөхнө.

Хэсэг 3. Үндсэн хөрөнгийн нийт хуримтлал

Нийт хөрөнгийн хуримтлал нь тайлант хугацаанд үйлдвэрлэгчээс шинээр эзэмшсэн үндсэн хөрөнгийн нийт өртгөөс ашиглалтаас хасагдсан үндсэн хөрөнгийн өртгийг хасч, дээр нь аж ахуйн нэгж, байгууллага өөрөө үйлдвэрлээгүй боловч, үйл ажиллагааных нь үр дүнд бий болсон өртгийг нэмсэн дүнгээр тодорхойлогдоно. Газрын үржил шимийг сайжруулах зорилгоор зарцуулсан хөрөнгө, тоног төхөөрөмжийг шинэчлэх, өргөтгөхтэй холбогдон гарсан зардал зэрэг нь энд орно.

Үндсэн хөрөнгө нь хөрөнгийн хуримтлалын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон нэг жилээс дээш хугацаанд үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд давтан эсвэл үргэлжлэн ашиглагддаг биет ба биет бус хөрөнгөөс бүрдэнэ. Нийт хөрөнгийн хуримтлалд бэлэглэсэн, үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгийг оруулж тооцно.

Мөр (49) **бусад байгууламж** гэсэн хэсэгт орон сууцны болон орон сууцны бус барилгаас бусад байгууламжууд, тухайлбал гудамж, суваг шуудуу зэрэг байгууламжууд орно.

Мөр (56) **ажлын болон ашиг шимийн мал, амьтан** гэсэн хэсэгт хувь хүн, байгууллагын хяналт, удирдлагын дор бүтээгдэхүүнийг давтан үйлдвэрлэх зорилгоор өсгөж буй үржлийн, сүүний чиглэлийн мал, ажлын мал, нэг жилээс дээш хугацаанд ашиг шимээ өгдөг мал, амьтныг оруулна. Тухайн жилд бойжуулсан төлөөс бусад мал, амьтныг өсөж үрждэг хөрөнгөд тооцно.

Мөр (57) **олон наст ургамал** гэсэн хэсэгт нэг жилээс дээш хугацаанд ургац авах зорилгоор ургуулж байгаа жимс, жимсгэний мод болон бусад таримал, модыг оруулна.

Мөр (62) **бусад биет бус хөрөнгө** гэсэн хэсэгт үйлдвэрлэлийн хэрэглээ нь хязгаарлагдмал, зөвхөн тухайн нэгжид өмчлөх эрх нь хадгалагддаг, эсвэл өөр нэгжид лиценцээр эзэмшүүлсэн хөрөнгө орно.

Мөр (73) **бусад үнэт зүйлс** гэсэн хэсэгт ямар нэгэн ангилалд ороогүй, жишээ нь үнэт чулуу, металлаар хийсэн үнэ цэнэтэй цуглуулга, гоёлын зүйлс орно.

Лавлах

Энэ маягтын талаар лавлах зүйл гарвал доорх утсаар холбоо барина уу.

Үндэсний Статистикийн Газар, МБПХГ-ын бизнес регистрийн алба

Утас: 327548 Факс: 324518 E mail: br_nso@yahoo.com

Хаяг: Үндэсний Статистикийн Газар

Засгийн Газрын III байр

Бага тойруу-44, Улаанбаатар-20а

**Төрийн бус болон олон нийтийн байгууллагын орлого, зарлагын
200.... оны тайлан маягтыг шинэчлэн боловсруулах тухай**

Албан ёсны статистикийн мэдээллийн үндэслэлийг сайжруулах, мэдээлэлд хамрагдах төрийн бус болон олон нийтийн байгууллагуудын хүрээг өргөжүүлэх, тэдгээрийн бусдыгаа төлөөлөх үзүүлэлтийг сайжруулах гол үндэслэл нь төрийн бус болон олон нийтийн байгууллагуудын сангийн үзүүлэлтийг байнга шинэчилж засвар, өөрчлөлтийг шуурхай оруулж байх явдал юм.

Төрийн бус болон олон нийтийн байгууллагын орлого, зарлагын жилийн мэдээ ТББ-1-ийг маягтаар жил бүрийн 3-р сарын 20-ны дотор төрийн бус болон олон нийтийн байгууллагуудаас авч боловсруулан засвар өөрчлөлтүүдийг тухай бүр оруулж ашиглаж байна. Энэ маягтыг ҮСГ-ын даргын 2000 оны 37-р тушаалаар баталсан.

Энэ маягтыг өөрчлөхийн өмнө МАХН, Монгол судлалын холбоо, Дашчойлон хийд, Соросын сан зэрэг байгууллагууд дээр судалгаа хийж, Төрийн бус байгууллагын тухай хуулиар зөвшөөрөгдсөн нэмэлт боломжуудыг ашигласны үндсэн дээр, хэрэглэгчдийн хэрэгцээг харгалзан төрийн бус байгууллагын орлого, зарлагын мэдээний маягт ТББ-1-ыг шинэчлэхээр боловсруулав. Төрийн бус болон олон нийтийн байгууллагын орлого, зарлагын тайлан ТББ-1 мэдээг аймаг, нийслэлийн статистикийн хэлтсүүдээр дамжуулан авч боловсруулан мэдээллийн сангийн өөрчлөлтийг хийж байхаар мэдээний урсгалыг өөрчилж байна. Үүнд:

Төрийн бус болон олон нийтийн байгууллагын орлого зарлагын
200... оны тайлан /ТББ-1/

2000 онд батлагдсан ТББ-1 маягтаар төрийн бус байгууллагын регистр, байршил, эрхэлж буй үйл ажиллагааны нэр, код, өмчийн хэлбэр, эдийн засгийн үзүүлэлтүүд зэрэг 9 үзүүлэлтийг авч байсан. Шинэчлэн боловсруулсан маягтаар нэгтгэн гаргуулахгүйгээр тухайн төрийн бус ба олон нийтийн байгууллага тус бүрээр авч боловсруулах юм.

I. Дараах үзүүлэлтүүдийг шинэчлэв.

А. Хаягийн хэсгийг дэлгэрэнгүй болгосон

Б. Эдийн засгийн үзүүлэлтийн орлогын хэсэгт өмнөх маягтанд ороогүй зарим нэгэн орлогыг нэмсэн /Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4-р бүлгийн 19-р зүйлд зааснаар/

В. Хөрөнгийн хэсгийг нэмсэн. /Үндэсний тооцоо, аргачлал судалгааны газрын санал болгосноор/

Г. Буцаж харилцах хаягийг нэмж тусгасан.

Шинэчилж байгаа маягт нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1. Хаягийн хэсэг /Тухайн байгууллагын регистр, нэр, оршин байгаа хаягийг дэлгэрэнгүй авна. /*
- 2. Эдийн засгийн үзүүлэлт /Орлого, зарлагын оны тайланг мян. төгрөгөөр илэрхийлэх/*
- 3. Хөрөнгө /Материаллаг эргэлтийн хөрөнгө, биет ба биет бус хөрөнгийг мян. төгрөгөөр илэрхийлэх/*
- 4. Харилцах хаяг /Буцаж харилцах хаягийг нөхөж тавих/*

II. Тухайн байгууллагын мэдээллийн үнэн бодит байдлыг хангах үүднээс дарга, эзэн, захирал, ня-бо нарын нэр, гарын үсгийг тамга, тэмдгээр баталгаажуулж авна.